

## БНХАУ-ЫН ХӨГЖЛИЙН ШИНЭ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ц.БАТБАЯР\*

2003 оны 10 дугаар сард хуралдсан 16 дахь удаагийн сонгуулийн ХКН-ын ТХ-ны 3 дугаар бүгд хурлаар Хятадын хөгжлийн шинэ үзэл баримтлалыг анх удаа зарлан тунхаглав. Хөгжлийн асуудлыг зөвхөн эдийн засгийн өсөлт, тухайлбал Дотоодын Нийт Бүтээгдэхүүний \ДНБ\ өсөлтөөр тодорхойлж байсан өмнөх 25 жилийн практикаас татгалзаж, хөгжлийг иж бүрнээр эдийн засаг, нийгэм, байгаль орчин, хүний хөгжил зэрэг бүх талыг хамарсан нийгмийн процесс гэж үзэх болов. Хөгжлийн асуудлыг цоо шинээр авч үзэх болсныг зөвхөн онолын болон үзэл суртлын шинэчлэлт гэж үзвэл өрөөсгөл болно. Харин ХКН-ын шинэ удирдлагын зүгээс өмнөх 25 жилийн эдийн засгийн өсөлтийн үр дүнд нийгэмд хуримтлагдсан зөрчилтэй асуудлуудад шүүмжлэлтэй бодитой хандаж тэдгээрийг засан залруулах, цаашдын хөгжлийг зөв удирдан жолоодох, нийгмийг зөрчлийг системийн хямрал болохоос урьдчилан сэргийлэх идэвхтэй эрэл хайгуул хийсний үр дүн бололтой.

Үзэл баримтлалын шинэчлэл хийхэд дотоод хоёр хүчин зүйл шууд түлхэц үзүүлсэн гэж гаднын ажиглагчид тэмдэглэж байна. Нэг нь 2003 оны хавар дэгдсэн САРС буюу амьсгалын замын хурц халдварт өвчин болно. САРС нь олон сая хүний эрүүл мэндэд заналхийлээд зогсохгүй, Хятад улсын эдийн засаг, түүний олон улсын нэр хүнд, удирдлагын чадавхид ноцтой үр дагавар авчрав. Хятадын удирдлага САРС-ын цар хүрээг нуух эсвэл дарах оролдлого хийснээр олон нийтийг төөрөгдүүлээд зогсохгүй, шийдвэр гаргахдаа олон нийтийн санал бодлыг тусгадаггүй, тэднийг үл ойшоодог,

шийдвэр гаргах механизм нь өнөөгийн нийгмийн хөгжлийн шаардлагад нийцэхгүй болоод байгааг хатуу ухамсарлажээ.<sup>1</sup>

Нөгөө хүчин зүйл нь БНХАУ –ын эдийн засгийн хөгжил тодорхой үе шатанд хүрч, нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ 1000 ам долларын босгыг давсанд оршино. Дэлхийн бусад орны жишээнээс авч үзэх юм бол үүний дараа хөгжлийн эгзэгтэй үе тулгардаг байна. Азийн барууд Өмнөд Солонгос, Сингапур, Тайван, Хонконг зэрэг нь эдийн засгийн өсөлтөө үргэлжлүүлж, ДНБ-ээ нэмэгдүүлж чадсан бол Латин Америкийн орнууд зогсонги байдалд орох, тэр ч байтугай ДНБ-ний өмнө хүрсэн түвшнээсээ ухрах хүртэл байдалд орж байжээ. Хямд ажлын хүч, дотоодын асар том зах зээлд дулдуйдан эдийн засгийн экстенсив өсөлтөө хангаж ирсэн Хятад улс эдгээр давуу талуудаа цаашид хэр удаан хадгалах, хөдөлмөр шингэсэн аж үйлдвэрээс технолог шингэсэн аж үйлдвэрийн бүтэц рүү шилжих, технологийн шинэчлэл хийх торгон зурвасыг мэдрэх мөчтэй тулгарчээ. Түүнчлэн 1997-98 онд болсон Азийн орнуудын санхүүгийн хямрал нь Тайланд болон Индонез зэрэг хөгжлийн түвшингээр ойролцоо орнуудын туршлагаас сургамж авах хэрэгтэйг ойлгуулав. Тэдгээр орнуудын банк санхүүгийн гаж байдал, хөрөнгө оруулалтыг төвөөс захиран зарцуулдаг дутагдал, эдийн засаг, нийгмийн тэнцвэргүй хөгжил зэрэг нь Хятадын эдийн засгийн шийдвэр гаргагчдын анхаарлыг татсан нь гарцаагүй.

“Цогц, тэнцвэртэй, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-ыг (Comprehensive, coordinated and sustainable concept of development) мөрдөхийн чухлыг БНХАУ-ын дарга Ху Жинтао 2003 оны 7 дугаар сарын 28-ны өдөр болсон

\* Ц. Батбаяр. Түүхийн шинжлэх ухааны доктор, МХСДТ-ийн Удирдах Зөвлөлийн дарга.

<sup>1</sup> Китай: угрозы, риски, вызовы развитию. С. 566-567. <http://www.carnegie.ru/ru/pubs/books/72887.htm>

САРС-тай тэмцэх Бүх Хятадын зөвлөлгөөн дээр анх дэвшүүлэн тавьжээ. Дараахан нь болсон 16 дахь удаагийн сонгуулийн ХКН-ын ТХ-ны 3 дугаар бүгд хурлын тогтоолд шинэ үзэл баримтлалын агуулгыг : хот хөдөөгийн хөгжлийн, бүс нутаг хоорондын, эдийн засаг ба нийгмийн хөгжлийн, хүн ба байгаль орчны, дотоод хөгжил ба нээлттэй гадаад бодлого хоорондын нийт таван тэнцвэрийг хангах гэж томъёолжээ. Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябао ч 2003 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Хонконгийн олон нийттэй хийсэн уулзалт дээр Хятадын шинэ удирдлага САРС-тай хийсэн тэмцлийн явцад онол практикийн чухал дүгнэлтэд хүрсэн тухай танилцуулжээ. Тэрээр мөн оны 11 дүгээр сард “Вашингтон Пост” сонины сурвалжлагчид өгсөн ярилцлагадаа дээрх таван тэнцвэрийг тайлбарлахдаа “нэг хөл нь нөгөөгөөсөө богино хүн”-тэй адилтгаж, тийм хүн тэгш алхаад явж чадахгүй, заавал ч үгүй унах болно гэдгийг анхааруулав.<sup>2</sup>

Хятадын судлаачид хөгжлийн асуудалд “шинжлэх ухаанчаар хандах” болсны бодит шалтгааныг тайлбарлахдаа 3 зүйлийг онцлон тэмдэглэжээ. 1978 оноос хойш, ялангуяа ГХӨ-ыг их хэмжээгээр татах болсон 1990-2003 оны 13 жилийн хөгжлийн үр дүнг авч үзвээс Хятадын хөгжил нь асар их хөрөнгө оруулалтын хүчээр түүхий эд, эрдэс баялгийг хайр найргүй цөлмөн ашигласны хүчин дээр тулгуурласан байв. Ийм экстенсив хөгжлийн уршигаар нэгд: хот хөдөө, хүн амын орлогын зөрөө улам өргөжих болсон, хоёрт: байгаль орчин асар ихээр доройтсон, гуравт: байгалийн баялаг, түүхий эдийг “ховх сорон” ашиглах болсон гэжээ. 1979-2004 оны хугацаанд эдийн засаг жил бүр дунджаар 9 хувь гаруй өсөж, Хятад дэлхийн 6 дахь том эдийн засаг болж хувирчээ. Хятадын ДНБ дэлхийн ДНБ-ний 4 хувьд хүрсэн боловч дэлхийн усны 15 хувь, ган төмрийн 28 хувь, цементийн 50 хувийг хэрэглэх болжээ. Ху Жинтао тэргүүтэй удирдлага ийм байдалд

дүгнэлт хийж, хөгжлийн экстенсив аргаас ангижирч, “шинжлэх ухааны арга ололтуудад” түшиглэсэн, цогц, тэнцвэртэй, тогтвортой хөгжлийн замд шилжих цаг болсныг соргоогоор мэдэрч шинэ үзэл баримтлалыг нэвтрүүлсэн гэжээ.<sup>3</sup>

АНУ-ын судлаач Э.Экономи Конгрессын дэд хороон дээр 2004 оны 9 дүгээр сард тавьсан илтгэлдээ сүүлийн 20 жилд хэрэгжсэн Хятадын “эдийн засгийн гайхамшиг” нь агаар, усны бохирдлыг асар ихээр нэмэгдүүлж, газрын доройтол, цөлжилтийг тэлж, байгалийн баялгийн хомсдолд хүргэсэн “байгаль орчны гамшиг” авчирлаа гэж дүгнэсэн байна. Хятадын хотуудын 2/3 -нь ДЭМБ-ын агаарын бохирдлын стандартыг хангахаа больж, 700 сая хүн ямар нэг хэмжээгээр бохирдсон ус уух болж, агаарын бохирдлоос үүдэлтэй амьсгалын замын өвчнөөс болж жилд дунджаар 300 мянган хүн нас барах болсон гэсэн баримтуудыг тэрээр илтгэлдээ дурджээ. Дэлхийн банкны тооцоогоор байгаль орчны бохирдол, доройтлоос болж учирч буй хохирол зардлын өртөг Хятадын ДНБ-ний 8-12 хувьтай тэнцэнэ гэжээ.<sup>4</sup>

Хот хөдөө, бүс нутаг хоорондын болон баян, ядуугийн орлогын зөрөө жилээс жилд нэмэгдэж Хятадын хөгжил, нийгмийн тогтвортой байдалд улам бүр сөрөг нөлөө үзүүлэх болсон тухай хятадын судлаачид бичиж байна. Хөдөөгийн тариачны жилийн орлогыг хотын оршин суугчийнхтай харьцуулбал 1985 онд 1: 2,57 байсан бол 2004 онд 1: 3,23 болж нэмэгджээ. Улс Төрийн Зөвлөлдөх Зөвлөлийн хийсэн судалгаанаас үзвэл жилийн цэвэр орлого нь 865 юань буюу түүнээс доош хүн амын тоо 90 сая буй бөгөөд тэд хөдөөгийн хүн амын 10 хувийг эзэлдэг ажээ.<sup>5</sup> Бүс нутаг хоорондын амьдралын түвшин мөн “газар тэнгэр” шиг зөрөөтэй болж байна. Бээжин, Шанхай зэрэг томоохон хотуудын хүн амын жилийн дундаж орлого 10,000 юань хүрч байна. Хятадын НШУА-ийн Социологийн хүрээлэнгийн хийсэн

2 Мөн тэнд, с. 569-570.

3 China Daily, October 10, 2005.

4 Congressional testimony: China's Environmental Challenges; Subcommittee on Asia and the Pacific, House International Affairs Committee, September 22, 2004. <http://www.cfr.org/publication.html?id=7391>

5 Widening income gap worries Chinese political advisors. [http://english.peopledaily.com.cn/200507/07/eng20050707\\_194725.html](http://english.peopledaily.com.cn/200507/07/eng20050707_194725.html)

судалгаанаас үзвэл Хятадын хүн амын 10 хувийг эзлэх баян чинээлэг амьдралтай хүмүүсийн гэр бүлийн дундаж орлого ядуу гэр бүлийн дундаж орлогоос 8 дахин их байна.<sup>6</sup>

2004 оны сүүлээр болсон 16 дахь удаагийн сонгуулийн ХКН-ын ТХ-ны 4 дүгээр бүгд хурлаар нийгмийн тэнцвэртэй хөгжлийг хангах үүднээс “өв тэгш социалист нийгэм” (Harmonious socialist society) бүтээн

байгуулах тухай зорилтыг дэвшүүлэв. Нийгмийн шударга ёс болон хүн амын амьдралын тэгш байдлыг хангах, тэгснээр “нэг хэсэг нь түрүүлж чинээлэгжих” онолоос “нийтээр чинээлэгжих” онолд шилжих тухай Хятадын цаашдын хөгжлийн стратеги, тактикт зарчмын чанартай өөрчлөлт гарч байна.

<sup>6</sup> Wealth gap threatens China's development. [http://english.peopledaily.com.cn/200412/16/eng20041216\\_167590.html](http://english.peopledaily.com.cn/200412/16/eng20041216_167590.html)